

СОЁЛ

**ДОРНОДАХИНЫ АРД
ТҮМНИЙ СЭТГЭХҮЙН СОЁЛЫН
УЛАМЖЛАЛТ ЗАРИМ
ОЙЛГОЛТЫН ТУХАЙ**

(Таван махабод, Арга билиг, Хоосон чанар)

Б. БОЛДСАЙХАН

Дорнодахины уламжлалт сурвалж бичгүүд, тухайлбал: философи, логик, одон орны судлал, анагаах ухаан, хэл шинжлэлийн зэрэг шинжлэх ухааны төрөл бүрийн салбараар эртний дорно дахины эрдэмтдийн туурвин бүтээсэн зохиолуудад: ТАВАН МАХАБОД (хам а), (АРГА БИЛИГ) (тав шарав), (ХООСОН ЧАНАР), (донвий нид) гэсэн нэр томъёонуудтай байнга тааралддаг.

Эдгээр нэршлүүд нь үзэл бодлын өргөн цар хүрээтэй илэрхийлэл төдийгүй, дорно дахины ард түмний оюуны соёлын үндэс нь болж, амьдралын үйл явцын дунд байгаль ертөнцийг урт хугацаагаар ажиглан шинжлээд хураангуйлж үгээр илэрхийлсэн дүгнэлт юм.

Бид энэхүү хийсвэрлэж томъёолсон дүгнэлтийн учир холбогдлыг материалист диалектикийн үүднээс тайлбарлан ухаарах нь сурвалж судалгааны ажилд зайлшгүй чухал асуудал билээ.

Дурдсан нэршлүүдийн чухам ямар утга санааг агуулж буйг товч төдийхөн дурдахаас биш, эрдэмтэн мэргэдийн үе улираан улам баяжуулан туурвисан шашдируудын гүнзгий утга агуулгаар юмс үзэгдлийг олон талаас нь авч үзэж байсан нарийн учрыг яахин тайлах билээ.

Таван махабод (маха-их, бод-бодис) гэсэн ойлголтонд: одон зурхайн таван махабод (шороо, ус, гал, хий, огторгуй), хар зурхайн таван махабод (мод, гал, шороо, төмөр, ус) гэсэн хоёр чиглэлийг хамруулан үздэг.

Одон зурхайн таван махабодын онол нь эртний Энэтхэг, Грекийн гүн ухааны гэнэн материалист үзлийн эрт үеийн (2500 жилээс өмнө) дөрвөн махабодын үзэл (шороо, ус, гал, хий)-ийн суурин дээр 2000 гаруй жилийн өмнө «Огторгуй» махабодыг нэмсэнийг Ньяя-Вейбхашик¹ сурвалжид тэмдэглэсэнээр үүсчээ.

Ийнхүү хүмүүс орчин тойрон болон өөрсдийгөө танин мэдэхийн тулд янз бүрийн сэтгэлгээг гарган үзэж байсан механик хандлагаас улам хөгжин гүнзгийрч юмс үзэгдлийн холбоо уялдаанд байх салшгүй таван шинжийг тодруулсан дүгнэлтэнд хүрсэн байна.

Энэ нь аливаа юмс: 1. бодитой байх нь ШОРОО мэт, 2. Харилцан уялдах нь УС мэт, 3. Эрчим хүчтэй байх нь ГАЛ мэт, 4. Хөдөлгөөнтэй байх нь ХИЙ мэт, 5. орон зайг эзлэх нь ОГТОРГУЙ мэт гэсэн таван салшгүй шинжийг одон зурхайн—таван махабодоор хийсвэрлэн томъёолсон ажээ.

Хар зурхайн таван махабод нь: мод, гал, шороо, төмөр, ус эдгээр 5-н зүйлийн бодисын чанар болоод хоорондын харьцаагаар юмс үзэгдлийн мөн чанар хийгээд харилцан нөхцөлдөх уялдааг тайлбарлажээ. Жишээлэн үзвэл: гал нь-төмөрт түшиглэж, ус нь-галд түшиглэдэг бол галд ус дайсагнаж, төмөрт-гал дайсагнана гэх мэтээр бүдүүвч ойлголтоос улам гүнзгийрүүлж, таван махабодын хоорондын уялдаа холбоог харил-

¹ Karunadasa Y: Buddhist analysis of matter Colombo, 1967 p 16

цан түшиглэх, харилцан хязгаарлах, эсэргүүцэх зэрэг агуулгатай хийгээд таван махабодын аль нэг нь хэтэрхий давамгайлах буюу хэтэрхий доройтохоос зайлсхийж, хоорондын зохих тэнцвэрт байдлыг хадгалж чадахуйцаар уг хийсвэрлэсэн томъёоллыг гаргажээ. Энэ нь 2000 жилийн өмнө эртний Хятадын материалист гүн ухааны үзлийн илэрхийлэл болж байсан² байна.

Таван махабодын хоёр чиглэлийн онолыг хооронд нь болон тус бүрд нь хураангуйлсан ойлголтыг АРГА БИЛГИЙН ёсоор харилцан шүтүүлж томъёолдог.

Тухайлбал таван махабодын эсрэг тэсрэг тал болох ГАЛ, УС хоёрт бусад махабодуудыг хураангуйлдаг. Энэ хоёр талын харьцангуй чанарыг ойлгохдоо; аргын талд-халууны туйл, нар, зун, гэрэл, эр, юмсын идэвхтэй, гадар тал гэх мэтчилэнгээр, билгийн талд хүйтний туйл, сар, өвөл, харанхуй, эм, юмсын идэвхгүй, гүнзгий далд тал гэх зэргээр юмс үзэгдлийн шүтэн барилдсан хоёр талыг илтгэж буй эдгээр жишээ нь бидний ойлголт төсөөлөлд ил тод байдаг мэдээжийн уялдаа холбоосууд юм. Таныж мэдэхэд бүдэг бүрхэг байдаг юмс үзэгдлийн дотоод гүнзгий талыг мөн адилаар хийсвэрлэн үздэг ажээ.

Арга билгийн харьцаа нь хоёр туйлын энергийн хүчний динамик харилцан үйлчлэлээр хоорондын тэмцэл, нэгдлийг тодорхойлдог.

Орчлон бол арга билгийн өөрчлөлтийн хүчний хэлбэлзэл мөн³ гэж сурвалж бичигт тэмдэглэсэн ч байдаг. Энэхүү ойлголтыг Ф. Энгельсийн⁴ бичсэн: «Ер нь хөдөлгөөн өөрөө л зөрчил юм, энэ бол эсрэг тэсрэг хоёр тал, тасалдах, үл тасалдахын нэгдэл мөн» гэсэн дүгнэлтийн үүднээс уг асуудалд хандаж байна.

Дорно дахины ард түмний эртний сурвалж бичгүүдэд орчлон ертөнцийн юмс үзэгдлүүдийн холбоо харьцааг дээрх онолоор тайлбарлахын зэрэгцээгээр байгаль ертөнцийн салшгүй хэсэг нь гэж хүний бие махабодын үйл ажиллагааны зохицуулах системийг таван махабод, арга билгийн онолоор тайлбарладаг. Энэ нь тухайн үеийн материалист үзлийн гүн ухааны зэвсгийг эзэмшээд сая анагаах ухааны ойлголтоо онолын талаар нь системчилсэн нь тодорхой. Энэ үүднээс бие махабодын дотоод нарийн үйл ажиллагааны уялдаа холбоог «гурван гэм»-ийн онолоор тайлбарладаг. Үүнд: 1. ХИЙ, 2. ШАР нь гал махабодтой, 3. БАДГАН нь шороо, усан махабодтой, Огторгуй махабод нь ХИЙ, ШАР, БАД ГАНА гэсэн гурван гэмдээ түгэнэ гэх мэтээр одон зурхайн таван махабодын онолоор тайлбарласан байдаг.

Өвчин бүхний мөн чанарыг хий, шар, бадгана 3-д буюу үүнийгээ хураангуйлан: ХАЛУУН (шар), ХҮЙТЭН (бадгана) 2-т (арга билгийн ёсоор) хураангуйлан ялгаж таних лугаа нягт уялдуулсан болохоор биеийн зүй, өвчний зүй, эмт бодисын ухаан зэрэг нь одон зурхайн таван махабодын онол дээр өргөн хэмжээгээр тусгалаа олсон байдаг. Энэ нь тухайн үедээ таниж мэдэхэд бүдэг байсан бие махабодын дотоод нарийн зүйл ажиллагааны уялдаа холбоог, шим ертөнцтэй холбон хийсвэрлэсэн сэтгэхүйн гүнзгий сэтгэлгээ юм.

Харин хар зурхайн таван махабодын онолоор дөрвөн улирал хийгээд таван цул (элэг, зүрх, дэлүү, уушиг, бөөр), зургаан сав (цөс, нарийн гэдэс, ходоод, бүдүүн гэдэс, давсаг) эрхтэнүүдийг мод, гал, шороо,

² Needham J. Science and Civilization in China. Vol. 2. Cambridge. 1956

³ Yoshio Manaka M. N. The Lavman's Gude to Acupumcture. New York Weatherhili. Tokyo, 1980. p. 31

⁴ Ф. Энгельс, «Дюрингийн эсрэг» УБ. 1979-р тал

төмөр, ус таван махабодод төрөлжүүлэн эх, хүзүүн, нөхөр, дайсаны харьцаагаар цул савын эрхтэнүүдийн хоорондын үйл ажиллагааны харилцан түшилцэх, харилцан харшилдах мэтчилэнгээр дотор эрхтний үйл ажиллагааны нарийн төвөгтэй холбоо харьцааг илэрхийлэхээс гадна дөрвөн улирал, цаг хугацааны хэмнэлтэй холбогдох эрхтний үйл ажиллагааг уялдуулан үздэг байна. Иймээс хар зурхайн таван махабод нь биеийн тодорхой эрхтнүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог гаргаж илэрхийлсэн биеийн таван махабодын онол гэж үзэж болох талтай.

Нэг чиглэл нь эртний Энэтхэг, Грекээс гаралтай, нөгөө нь Хятадын гүн ухааны хуудам материалист урсгалаас эх үүсвэр авч улам гүнзгийрсэн хийсвэр сэтгэхүйн хоёр чиглэлийн таван махабодын онолыг хүний бие сэтгэхүйн талд зэрэгцүүлэн тавьж уялдуулан улам гүнзгийрүүлэн хийсвэрлэсэнээр Монголын уламжлалт эмнэлгийн онолын системийн онцлог тал нь тодордог.

Таван махабодын энэхүү хоёр чиглэлийн хоорондын ялгаа, гол учир уялдааг харгалзахгүйгээр адилтгах, эсвэл аль нэгийг нь үгүйсгэх хандлага байж болохгүй юм.

Ингэж таван махабодын онол нь хүн бол байгаль ертөнцийн салшгүй хэсэг нь гэж үзэж байсны эрт үеийн үзэл санааны илрэл нь болдог. К. Маркс энэхүү ойлголтыг жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй болгосон юм. Тэрээр хэлэхдээ: Байгалийг хүний органик биш бие» гэж анх удаа тодорхойлоод «хүн байгалийн хүчинд аж төрж байгаа» бөгөөд хүн байгалиас амьдралынхаа бүхий л хэрэгслийг авч байдаг⁵ гэж заан тэмдэглэсэн.

Таван махабод, арга билгийн онолын харьцангуй, шүтэн барилдах утгыг ХООСОН ЧАНАР-аар улам гүнзгийрүүлэн хийсвэрлэдэг байна.

Хоосон чанар нь: аливаа юмсын үндэс, «үнэн байгч» чанарыг тэмдэглэхийн тулд хэрэглэсэн энэхүү гүнзгий хийсвэрлэлийг үгээр илэрхийлсэн нь ертөнцийн бүх юмс үзэгдлийг харьцангуй оршихыг зөвшөөрсөн хийгээд дотоод гол чанар, тэдгээрийн орших гол байдлыг илэрхийлж буй категори болно.⁶ Хоосон чанар нь аливаа үзэгдлийн эерэг сөрөг талуудын уялдааг харьцангуйгаар авч үздэг төв үзэл (матъямика) учраас таван махабодын хоорондын харилцан уялдааны тэнцвэр, арга билиг, халуун, хүйтний завсрын нэгдэл, тэнцвэрт байдлыг гүнзгий хийсвэрлэн дүгнэх танин мэдэхүйн арга хэрэгсэл нь тухайн үедээ болж байжээ. Энэхүү харилцан шүтэлцэх талууд жишээлбэл: цаг хугацааны эргэлтээр өдөр, шөнө болох нь сэргэлэн цовоо хийгээд унтах, сэрэл, саатал, булчингийн хүчдэл, түүний сулралтай, зун, өвөл болох нь халуун, хүйтэн, биеийн дотоод энергийн ихсэх, багасахтай шүтэлцэнэ. Ийнхүү өдөр, шөнө, өвөл, зунд тэнцвэрт зааг байдаг шиг бие сэтгэхүйн эерэг, сөрөг талуудын тэнцвэрт байдлыг холбож, ёгийн сургуулилтыг явуулдаг онолын зарчмыг «хоосон чанарын» үүднээс тайлбарладаг. Энд л «хоосон чанар» гэдэг ойлголт нь нэн гүнзгийрч нарийссан хийсвэр сэтгэлгээний үр дүн болох нь товойн гардаг. Энэ нь дорно дахины анагаах ухааны ойлголтоор хүний биеийн эрхтэнүүдийг энерги ялгаруулдаг, энерги хуримтлуулдаг эрхтэн гэж эерэг, сөрөг талд хамруулан үздэгтэй холбоотой юм. Эдгээр эрхтэнүүд хоорондоо тодорхой суваг, хирдэсээр холбогддог болохыг зургаар хийсвэрлэн томъёолсон байдаг. Энергийн урсгалууд нь эрхтэн системүүдэд тодорхой үет хугацаанд ихсэж, багасах нь цаг, улирал, жилийн эргэлтийн хэмнэлээр явагддаг нь хар зурхайн таван махабодын

⁵ К. Маркс, Ф. Энгельс Эртний үеийн зохиолоос М. 1956, 565 дахь тал

⁶ Г. Лувсанцэрэн, Нагаржунайн философийн үзэл. УБ. 1982. 32 дахь тал

онолоор тайлбарлагдаж, энергийн эерэг, сөрөг талын тэнцвэрт байдлыг хангах нь биеийн дотоод энергийг ихэсгэж, бие махабодын тэнцвэрт байдлыг батжуулан эрүүл байхын нөхцөл гэж үздэг. Энэ үзэл онолоос үүдэн гарсан эмчилгээ, урьдчилан сэргийлэх, заслын аргууд нь: олон бүтэцт жор найрлагууд, иогийн дасгал, зүү төөнүүр засал зэрэг олон болсон нь өгсөн нэрийн утгаар ч гэсэн нар, сарны хэмнэл нь хүний бие арга хэлбэрүүдэд уламжлан хэрэглэгдэх болжээ. Тухайлбал: хатха иогоор (ха-нар, тха-сар, иог-төгс учрах гэсэн утгатай санскрит үг) сургуульлах махабодь, сэтгэл санаанд нөлөөлөн зохицож байдаг эсрэг, тэсрэг талын шүтэлцэн орших тэнцвэрт байдлыг тусгаж, бие сэтгэхүйн эерэг, сөрөг талуудын тэнцвэрт байдлыг холбож, дотоод хүч чадлаа шавхан дайчлах нь эрүүл энх урт удаан наслахын үндэс болохыг илтгэжээ. Хатха иогийг цаашид хөгжүүлэн, бодол санаагаа гүнзгийрүүлэн хуралдуулсны хүчээр гадны олон талт сэрлээс ангижиран, биеийн дотоод хүчийг олж, ямар нэгэн хүсэл эрмэлзлэлийн туйл болох билгийн чанад хүрэх дасгал сургуулилтын системийг одон зурхайн таван махабодь, хоосон чанарын үүднээс гүн хийсвэрлэсэн дүгнэлтийг хийдгээрээ «хоосон чанар» гэсэн ухагдахууныг хамгийн дээд түвшинд гүнзгийрүүлэн тавьсан хэсэг нь болдог.

Энэ нь бодисын дөрөвдөгч төлөв болох эерэг ба сөрөг сул цэнэгүүдийг агуулсан цахилгаан саармаг төлөвт байгаа бодисыг «плазм» гэж физикт нэрлэдэг нь хүний бие махабодид «биоплазм болж байдгийг эрдэмтэд уялдуулан нээсэн⁷ хийгээд, сэтгэхүйн гойд чадвартанд бодол санаагаа төвлөрүүлэх үед био-энергийн хуримтлалыг ихэсгэж, биоплазмыг гайхалтай бат тогтвортой нягтруулж, энэхүү орчинд биоломенисценцийн (цацрах үзэгдэл болон гэрлийн долгион тархах үзэгдэлд үндэслэж аливаа юмсыг эзэлхүүнээр нь тусгах шинж чанарууд байгаа зэрэг бусад олон чанарыг тодруулан судалж байгаагаар сэтгэхүйн үзэгдлийн гойд чадварыг нээн илрүүлж буй орчин үеийн судалгааны нөр их үйлсийн үр дүнг, эртний энэхүү хийсвэрлэлээр билэгдэн томъёолж, бодит үр дүнд хүрэхүйц гүнзгийрч нарийссан хийсвэр сэтгэлгээний системийг загварчлан боловсруулсан байж болохыг ч үгүйсгэх учиргүй.

Буддизм бол дан ганц шашин ч бус, дан ганц шинжлэх ухаан буюу философи ч бус. Харин буддын шашин дэлгэрч, нийгмийн амьдралд нь гүн нэвтэрсэн орнуудад хөгжиж агсан соёл, шинжлэх ухааны ололт, үзэл санааны урсгалуудыг шашны хамтаар «буддизм» хэмээх нэгэн нэрийн дор нэгтгэн ойлгох болсон ажээ.⁸ Таван махабод, арга билиг, хоосон чанарын сургаал ч мөнхүү буддизмийн дотор диалектик ба логик сургаал нь болж, уг үзэл санаагаар сэтгэцийн нэн нарийн үзэгдлийг ерийн биш, ид шидийн зүйл буюу оюун ухааны гажиг гэж үзэхгүй, харин ч тухайл сан тодорхой нөхцөлд хүний оюуны илрэл чадал гэж ухаардаг байжээ.

⁷ В. И. Инюшин. П. Р. Чекуров Биостимуляция лучом лазера и биоплазм. Алма Ата 1975, 55-р тал

⁸ Г. Лувсанцэрэн. Нагуржунайн философийн үзэл УБ. 1982. 11 дэх тал